



## МОНГОЛЫН ЭМ ЗҮЙН БАЙГУУЛЛАГУУДЫН НЭГДСЭН ЭМ ХОЛБОО

2014 он 6 сарын 13 өдөр

№ 033

БГДүүрэг 4-р хороо Дунд голын 1-р гудамж  
“Монгол түлхүүр” ХХК байр А корпус  
E-mail:mezbneh@yahoo.com  
Утас: 70180723, 99116233  
Факс: 976-11-70180724

### УЛСЫН ИХ ХУРАЛД

#### Уриалга хүргүүлэх тухай

Төрөөс эмийн талаар баримтлах бодлого болон холбогдох хууль, эрх зүйн баримт бичигт өөрчлөлт, шинэчлэлт хийх, Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн хөрөнгө оруулалтын чуулга, уулзалт зэрэг томоохон арга хэмжээг зохион байгуулж байгаад манай салбарын хамт олон баяртай хүлээн авч, хэрэгжүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлэхийн ялдамд хамт олны санал бодлыг хэлэлцэн зөвлөгөөн зохион байгуулсан юм.

Иймд МЭЗБН “Эм” Холбоо ТББ-аас 2014 оны 05 дугаар сарын 31-нд Эм хангамжийн салбарын Удирдах ажилтаны “Эм хангамжийн салбарт тулгамдаж буй асуудлууд” садэвт улсын зөвлөгөөний уриалгыг Төр засаг, яам, агентлагуудад хүргүүлж байна.

Та бүхэн танилцаж, бидний уриалгыг дэмжиж, хамтран ажиллана гэдэгт гүнээ итгэж байна.

Уриалгыг хавсаргав.

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал



О.ДАМБА

**Эм хангамжийн байгууллагын Удирдах ажилтаны улсын зөвлөгөөнөөс**

**гарсан уриалга**

2014.05.31

Улаанбаатар хот

**Нэг. Үндэслэл**

- 1.1. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болсон эмийн үндэсний бодлого, хууль, стандартыг хэрэгжүүлэхэд дотоодын эмийн үйлдвэрлэл, хангамж, эмийн сангийн үйлчилгээг сайжруулах, үйл ажиллагааг зөв зохицуулах зэрэг асуудалд төр засгаас анхаарч хөрөнгө, хүч гаргах хэрэгтэй байна.
- 1.2. 1990 он хүртэл Улсын 5 үйлдвэр, орон нутгийн 21 эм хангамжийн салбар, 300 гаруй эмийн сан ажиллаж байсан бол одоогийн байдлаар эмийн үйлдвэр 32, Эм хангамжийн салбарын 144 гаруй, эмийн сан 1200 орчим болж ажиллагсдын тоо 15 дахин өссөн бөгөөд эдгээр нэгжүүдийн 96 хувь нь хувийн хэвшлийнх байна.
- 1.3. Эм зүйн салбарын эрх зүйн орчин бүрдсэн боловч, түүнийг зохицуулж хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоо зөв бүрдээгүйгээс эмийн үйлдвэрлэл, импорт, хангамж, чанар хэрэглээнд төрийн зүгээс тавих зохицуулалт, хяналт хангальгүй байгаа нь ДЭМБ-ын эмийн зохицуулалтыг үнэлэх аргачлалын дагуу 2011 оны 12-р сард Монгол улсын эм зүйн салбарын зохицуулалтын өнөөгийн байдлыг үнэлэхэд 626 асуултаас 294 асуулт эзрэг үзүүлэлттэй гарч, эмийн зөв зохистой зохицуулалт 46,9% байгаагаас харагдаж байна.
- 1.4. Өнөөгийн байдлаар эмийн зохицуулалтын 33 үйл ажиллагааг улсын 5 байгууллага буюу 12 нэгж тусдаа гүйцэтгэж байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт бий болж, албан тушаал, ажил үүргийн давхардал гарч, мэргэжлийн нэгдсэн зохицуулалт, удирдлага алдагдсаныг харуулж байна.
- 1.5. Иймд 2014 оны 5 сарын 31-нд болсон Эм хангамжийн байгууллагын улсын зөвлөгөөнд тавигдсан илтгэлүүд болон оролцогчдоос гаргасан саналыг үндэслэн доорх уриалгыг гаргаж байна.

**Хоёр. Засгийн газар, Эрүүл Мэндийн Яаманд**

- 2.1. Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн 2013 оны 03/03 тоот зөвлөмжийн нэгдүгээр заалтын дагуу Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, уламжлалт эмийн бүртгэл, эдгээрийн чанар, үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл аж төрөх эрхийг баталгаажуулахад зайлшгүй үгүйлэгдэж байгаа төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэх бие даасан эмийн эсхүл эм, хүнсний зохицуулалтын асуудал эрхэлсэн удирдах газар, агентлагийг бусад улс орны жишгийн дагуу байгуулах.
- 2.2. Шинжлэх ухаан, эрүүл мэнд, спорт болон хүн амын тодорхой бүлэг давхрагын эрх ашгийг хамгаалах чиглэлээр нийгмийн тусын тулд үйл ажиллагааг явуулж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжиж гүйцэтгэж буй ажил үүрэгт нь тохирсон санхүүжилтийг төсөвт тусган төрөөс анхаарч ажиллах.
- 2.3. Эрүүл мэндийн даатгалын механизмыг боловсронгуй болгож, жороор олгох эмийн үнийг 100% даатгалд хамруулах замаар жор бичилт, жороор эм олголтын асуудлыг шийдвэрлэх.
- 2.4. Эмийн жор бичилтийн стандарт, жороор үйлчлэх журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгож, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах

- 2.5. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагаанд үнийг бус чанарыг голлон сонгон шалгаруулалт явуулах, хэрэгжилтэнд нь мониторингийн шалгалт хийдэг нөхцөлийг бүрдүүлж, хэрэгжүүлэх.
- 2.6. Эм ханганд нийлүүлэх байгууллагын ихэнх нь өндөр түрээстэй байранд үйл ажиллагаа явуулж, зах зээлийн урсгалаа дагаж хэт төвлөрснөөс түрээсийн үнийг өсгөж стандарт хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байгаа учраас цаашид дэд бүтэц сайтай газар нэгдсэн цогцолбор байдлаар олон улсын чанарын шаардлагад нийцсэн агуулах барихад төрөөс дэмжих.
- 2.7. Эм хангамжийн байгууллагад олгосон тусгай зөвшөөрлийг шалгаж судлах, тусгай зөвшөөрлийн шаардлагын босго, олгох эрхийн асуудалд анхаарах, ТББ-ын санал авч шийдвэрт тусгах.
- 2.8. Эмийн төлөөлөгчдийн газрын ажиллах журам, эрх үүргийг тодорхой болгон, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах.
- 2.9. Эм барих эрх олгох лиценз, мэргэжил дээшлүүлэх давтан сургалтын асуудлыг салбарын мэргэжлийн төрийн бус байгууллага хариуцдаг болох эрх зүйн орчинг бүрдүүлэх.
- 2.10. Жижиг, дунд үйлдвэрийг төсөлд хамруулах бодлого баримтлан, төсөл хэрэгжүүлэхэд хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх.
- 2.11. Үндэсний эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүний зах зээлийг хамгаалах зорилгоор дотоодод үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнтэй ижил нэр төрлийн бүтээгдэхүүний импортонд хязгаарлалт тогтоох бодлого хэрэгжүүлэх.
- 2.12. Жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж импортоор оруулахад гааль, НӨАТатвараас чөлөөлөх тогтоолын хүчинтэй хугацааг сунгах.
- 2.13. Цаашид олон улсын GMP-ын шаардлага хангасан эмийн үйлдвэрийг байгуулахад төр засгаас бодитой дэмжлэг туслалцаа үзүүлэн, нэгдсэн цогцолбор байгуулахад зориулан дэд бүтэц бүхий газар олгох.
- 2.14. Эм эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаажилтын үйл ажиллагааг боловсронгуй болгож бүтээгдэхүүнийхээ чанарыг үйлдвэрлэгч, импортлогч, эмийн сан бүрэн хариуцах эрх зүйн тогтолцоог бий болгож хариуцлага тооцох механизмыг сайжруулах.
- 2.15. Эмнэлгийн эмийн сангийн үйл ажиллагааны стандарт, журам боловсруулах, клиник эмзүйчийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь эрх үүргийг баталгаажуулах, стандартын дагуу орон тооны асуудлыг шийдвэрлэх, Зохион байгуулалтыг олон улсын төвшинд хүргэх цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх.
- 2.16. а/ Хөдөө сумын хүн ам, эмнэлэгт эмийн хангамж үйлчилгээ үзүүлж буй эргэлтийн эмийн санг сумын эмнэлэгт нэгтгэх, эргэлтийн эмийн санд ажиллагсдын тэтгэвэр тэтгэмж, цалинг эмнэлэгт ажиллагсадтай адил түвшинд хүргэх.  
 б/ Сумын эмийн сангийн үйл ажиллагааг бие даасан хуулийн этгээд, аж ахуйн нэгж болгон өөрчилж тэднийг чанартай, өндөр идэвхтэй, боломжийн үнэтэй эмээр жигд хүртээмжтэй хангахад орон нутгийн засаг захиргаа хяналт тавьдаг болгож, мөн даатгалаас хөнгөлөлттэй олгох эмийн нэр төрөл, төсвийн хэмжээг нэмэгдүүлэн хөдөөгийн хүн амыг бүрэн хамруулдаг болгох
- 2.17. Бүх шатны боловсролын сургуульд “Эмийн зохистой хэрэглээ”-ний хичээл заах хөтөлбөр гаргаж мөрдүүлэх.

### **Гурав. Нийслэлийн Эрүүл Мэндийн Газарт**

- 3.1. Эм ханганд нийлүүлэх байгууллага, эмийн сангийн тоо, байршил, даатгалын жороор үйлчлэх эмийн сан нь зах зээлийн болон үйлчилгээний шаардлагад нийцэхгүй байгаад дүгнэлт хийж, оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх.
- 3.2. Бүх хувийн хэвшилийн эмнэлэгт эмзүйч ажиллуулан, эмийн аюулгүй байдал, зохистой хэрэглээнд мэргэжлийн хяналт тавих. Эмнэлгийн дэргэд стандартын шаардлага хангаагүй эмийн сан ажиллуулахыг зогсоох.

- 3.3. Дүүрэг буюу томоохон хороололд хүүхэд, өндөр настанд зориулсан төрөлжсөн эмийн санг байгуулж ажиллах.
- 3.4. Өрхийн эмнэлэг болон бусад эмнэлгүүд ойролцоо эмийн сантай эмийн зохистой хэрэглээний хүрээнд хамтран ажиллах, мэдээлэл солилцох, ард иргэдэд зориулан мэдээлэл сурталчилгаа хийдэг болж хэвшүүлэх.

#### **Дөрөв. Эм хангамжийн салбарын хамт олонд**

- 4.1. Эмийн тухай төрөөс баримтлах бодлого, хууль, дүрэм, журмыг мөрдөж, эм зүйчийн ёс суртахууныг дээдлэн, эмчилгээний өндөр идэвхитэй, чанартай эмээр, боломжийн үнээр, хөнгөн шуурхай үйлчилж, мэдлэг боловсролоо цаг ямагт дээшлүүлж, орчин үеийн анагаах ухаан болон эм зүйн шинжлэх ухааны ололт амжилт, мэргэжил нэгт нөхдийн туршлагыг үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллацаа.
- 4.2. Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сангийн тоо манай улсын хүн ам, нутаг дэвсгэрийн байршил, төвлөрөлтэй харьцуулахад илүүдэх хэмжээтэй, аймаг хотын төвд хэтэрхий төвлөрсөн, даатгалын жороор үйлчлэх эмийн сан цөөн байгаа нь иргэдэд хүрэх эмийн сангийн үйлчилгээ дутагдалтай байгаад дүгнэлт хийж өөрчлөлт шинэчлэлт хийхэд дэмжин оролцох.
- 4.3. Эм ханган нийлүүлэх байгууллагын ихэнх нь өндөр түрээстэй байранд үйл ажиллагаа явуулж, зах зээлийн урсгалаа дагаж хэт төвлөрснөөс түрээсийн үнийг өсгөж стандарт хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байгаа учраас цаашид дэд бүтэц сайтай газар нэгдсэн цогцолбор байдлаар олон улсын чанарын шаардлагад нийцсэн агуулах барихад хамтран төсөл боловсруулан оролцох.
- 4.4. Төвөөс алслагдсан аймгуудад мэргэжил дээшлүүлэх бүсчилсэн сургалт, семинар, онлайн сургалтыг тогтмол зохион байгуулах, мэргэжлээ бие даан дээшлүүлэх хэвлэл, гарын авлага материалыар хангах, төгсөлтийн дараах сургалтын тогтолцоог боловсронгуй болгох асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлүүлэх, идэвхи санаачлагатай оролцох.
- 4.5. Мэргэжлийн ёс зүйн талаар салбарын хэмжээнд судалгаа явуулж, сургалт, семинар зохион байгуулах, Эмзүйн "Алтан дүрэм"-ийн талаар асуулга, судалгаа авч, тангарагтай болох.
- 4.6. Байгалийн гаралтай эмээр олон улсын зах зээлд өрсөлдөх чиглэл баримтлах, нано, биотехнологийн чиглэлтэй үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх асуудлыг анхаарч эмийн үйлдвэрлэлийг төрөлжүүлэх, дагнах, хорших чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх.

#### **Тав. Иргэдэд**

- 5.1. Ард иргэд эмийн санд очихынхоо өмнө эмчид хандаж оношоо тогтоолгосны дараа эмээ жороор авч хэвших.
- 5.2. Эмийн тунг нь тааруулвал эм, эс тэгвээс хор гэдгийг алхам тутамдаа санаж, аливаа эмийг эмч, эмзүйчийн зөвлөгөөгүйгээр дур мэдэн хэрэглэхээс татгалзах.

#### **Эрүүл энх, сайн сайхныг хамтдаа бүтээцгээ.**

Зөвлөгөөнд оролцогсод,

МЭЗБН "Эм" Холбоо ТББ